



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

2023 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны 33 дугаар тэмдэглэлд:

XXXIII.1.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын төсөвт болон Ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн тухай.

ТЭМДЭГЛЭСЭН нь:

Төсвийн тухай хууль, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, Ирээдүйн өв сангийн 2023 оны төсвийн тухай хуулийг тус тус үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 307, 2023 оны 341 дүгээр тогтоолоор тус тус төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Улсын төсөв болон Ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн хэмжээг тус тус тогтоосон.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 307 дугаар тогтоолын хэрэгжилт 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгаар 46,1 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 29,7 тэрбум төгрөгийг төвлөрүүлж хэрэгжилт 64,4 хувьтай, Ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгаар 535,5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 441,8 тэрбум төгрөгийг төвлөрүүлж хэрэгжилт 82,5 хувьтай байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 341 дүгээр тогтоолын хэрэгжилт 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгаар 59,7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 27,0 тэрбум төгрөгийг төвлөрүүлж хэрэгжилт 45,2 хувьтай, Ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгаар 552,0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 256,2 тэрбум төгрөгийг төвлөрүүлж хэрэгжилт 46,4 хувьтай байгааг тэмдэглээд.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Улсын төсөвт болон Ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийг төвлөрүүлэлтийн талаар хийсэн танилцуулгыг сонсож, дараах чиглэлээр санал боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэв.” гэжээ.

1.Монгол улсын төсвийн тухай хууль болон Ирээдүйн өв сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухайн онд улсын төсөвт болон Ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийг төвлөрүүлэх чиг

132320184
33-r huraldaan.docx

үүргийг тухайн хуулийн этгээдийн Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч болон Төлөөлөн удирдах зөвлөлд хариуцуулж, Ногдол ашгийг төвлөрүүлээгүй тохиолдолд тухайн хуулийн этгээдийн Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч, Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагад хариуцлага тооцож байх.

2.Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн эцсийн санхүүгийн тайлангаар гарсан цэвэр ашгийн 50 хувь, эсхүл төрд ногдох эздийн өмчийн 1 хувьтай тэнцэх дүнгийн аль өндөр хэмжээгээр төрийн өмчийн ногдол ашиг тооцон хуваарилж, төсөвт төвлөрүүлэх талаар гарсан Улсын Их Хурлын 2021 оны 88 дугаар тогтоолын холбогдох заалтад өөрчлөлт оруулах.

3.Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хууль тогтоомжууд өөр хоорондоо зөрчилдөж байгаа байдлыг өөрчилж, төрийн болон орон нутгийн өмчийн талаарх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, түүний дотор төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн улсын төсөвт болон Ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн бодлогыг тодорхой болгох.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

